

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хуульчийн эрх зүйн байдал, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэжлийн нэр хүнд, хариуцлага болон хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж**

2.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хууль, Прокурорын тухай хууль, Нотариатын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хуульч” гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хүнийг;

3.1.2.“хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг энэ хуулиар тогтоосон зарчим, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг баталгаажуулсан албан ёсны баримт бичгийг;

3.1.3.“хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн хуульд заасан чиг үүргийн болон хуульчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, хууль зүйн сургуульд багшлах, судалгааны ажил эрхлэх зэрэг мэргэшлийн бэлтгэл, ур чадвар шаардсан үйл ажиллагааг;

3.1.4.“Хуульчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа” гэж энэ хуулийн 27 дугаар зүйлийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хуулийн этгээдийн хуульч, хуулийн зөвлөхийн болон төрийн байгууллагын хууль зүйн асуудал хариуцсан нэгжийн албан тушаалыг, эсхүл хуульч ажиллахаар заасан албан тушаал эрхлэхийг;

3.1.5.“хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага” /цаашид “Хуульчдын холбоо” гэх/ гэж хуульчдын заавал гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг;

3.1.6.“хуульч профессор” гэж Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд багшилж байгаа багш хуульчийг;

3.1.7.“хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа” гэж хуульчийн хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг мэргэжлийн чиг үүргийн хүрээнд хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих зорилготой аливаа үйл ажиллагааг.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

4.1.Хуульчийн мэргэжлийн шалгалт, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтыг хангах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаан дахь зөрчилтэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх, дүгнэлт гаргах, хуульчид хариуцлага ногдуулах зэрэг харилцааг энэ хуулиар зохицуулна.

4.2.Шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн мэргэжлийн үйл ажиллагаа, түүний хүрээн дэх зөрчилтэй холбогдсон харилцааг тус тусын хуулиар зохицуулах бөгөөд Хуульчдын холбооны эрх бүхий хороо дүгнэлт гаргах замаар зөрчлийг хянан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.3.Шүүгч, прокурор, өмгөөлөгчөөс бусад хуульч нь энэ хуульд заасан хүрээнд иргэн, аж ахуйн нэгжид хууль зүйн туслалцаа үзүүлж болно. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй хуульч өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх утга, агуулга бүхий гэрээ, хэлцэл байгуулах замаар бусдыг төөрөгдүүлэхийг хориглоно.

4.4.Хуульчдын холбоо өмгөөлөгчдийн бүртгэл, лавлагааг өөрийн цахим хуудсандаа нээлттэй байршуулах бөгөөд Өмгөөлөгчдийн холбоо зохих мэдээллээр хангана.

#### **5 дугаар зүйл.Хуульчийн эрхэмлэх зүйл, ерөнхий үүрэг**

5.1.Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаагаа үнэнч шударгаар гүйцэтгэнэ.

5.2.Хуульч нь олон нийтэд хүндлэл, итгэл хүлээхүйцээр биеэ авч явна.

5.3.Хуульч нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг сайн дураараа явуулахыг эрмэлзэнэ.

## **6 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим**

6.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

6.1.1.хүний эрхэм чанарыг хүндлэх;

6.1.2.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;

6.1.3.аливаад бодитой, хүнлэг хандах;

6.1.4.шударга ёсыг сахих, хараат бус байх;

6.1.5.шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хүндэтгэх, хамгаалах;

6.1.6.нууцыг хадгалах, хамгаалах;

6.1.7.ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;

6.1.8.мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТ**

### **7 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн шалгалт**

7.1.Хуульчийн мэргэжлийн шалгалт /цаашид "хуульчийн шалгалт" гэх/-ын зорилго нь хуульчийн шалгалтад орох эрхтэй этгээдийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хангалттай мэдлэг, чадвар эзэмшсэн эсэхийг тогтооход чиглэнэ.

7.2.Хуульчийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд тэгш эрх, шударга ёсыг хангах, ил тод байх, хууль дээдлэх, олон нийтийн итгэлийг даах, хараат бус байх зарчмыг баримтална.

### **8 дугаар зүйл.Хуульчийн шалгалтын комисс**

8.1.Хуульчийн шалгалтыг Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооноос байгуулагдсан Хуульчийн шалгалтын комисс /цаашид "Шалгалтын комисс" гэх/ зохион байгуулна.

8.2.Шалгалтын комисст Хуульчдын холбооны гишүүн хуульч, төрийн албаны төв байгууллага, Хуульчдын холбооны Тамгын газар болон хуульч профессоруудын төлөөлөл орно.

### **9 дүгээр зүйл.Хуульчийн шалгалтад орох эрх**

9.1.Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн дагуу хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага хийсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй.

9.2.Гадаад улсын хууль зүйн сургуулийг төгссөн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох журмыг Хуульчдын холбоо батална.

## **10 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад орох тухай өргөдөл гаргах**

10.1.Энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан этгээд хуульчийн шалгалтад орох тухай өргөдлөө шалгалтын комисст гаргана.

10.2.Шалгалтын комисс энэ хуулийн 14.4-т заасан хугацаанд өргөдөл хүлээн авна.

10.3.Хуульчийн шалгалтад орохыг хүссэн өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

10.3.1.Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд гадаад улсын паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар;

10.3.2.эрх зүйч мэргэжлийн боловсролын дипломын хуулбар;

10.3.3.мэргэжлийн дадлагын тухай тодорхойлолт;

10.3.4.Хуульчдын холбооноос баталсан өргөдөл гаргагчийн маягтын дагуу бөглөсөн биеийн байцаалт;

10.3.5.шалгалтын бүртгэлийн хураамж төлсөн баримт.

10.4.Шалгалтын комисс нь хуульчийн шалгалтад орох тухайн иргэний өргөдөл, биеийн байцаалтын үнэн зөв байдлыг шалгах зорилгоор шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээллийг гаргуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд хандах эрхтэй.

10.5. Шалгалтын комисс нь шаардлагатай гэж үзвэл хуульчийн шалгалтанд орох тухай өргөдөлд хавсаргасан баримт бичгийн хуулбарыг эх хувьтай нь тулган үзэж баталгаажуулна.

## **11 дүгээр зүйл.Мэргэжлийн дадлага**

11.1.Энэ хуулийн 9.1-д заасан мэргэжлийн дадлага гэдэгт эрх зүйч мэргэжил шаардах дараах ажил, албан тушаал хамаарна:

11.1.1.шүүх хуралдааны нарийн бичгийн дарга болон шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчийн туслах;

11.1.2.хуулийн этгээдийн хуулийн зөвлөх, хууль зүйн асуудал хариуцсан орон тооны ажилтан;

11.1.3.хууль зүйн сургуулийн багш, туслах багш, төрийн байгууллага болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн судалгааны ажилтан.

11.2.Мэргэжлийн дадлага хийсэнд тооцох журмыг Хуульчдын холбооны зөвлөл батална.

## **12 дугаар зүйл.Хуульчдын холбоо өргөдлийг шийдвэрлэх**

12.1.Энэ хуулийн 12.2-т зааснаас бусад тохиолдолд өргөдөл гаргагчид хуульчийн шалгалтад орох зөвшөөрлийг жагсаалтаар баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

12.2.Дор дурдсан үндэслэл байвал Шалгалтын комисс хуульчийн шалгалтад оруулахаас татгалзана:

12.2.1.өргөдөл гаргагч энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

12.2.2.энэ хуулийн 10.3-т заасан баримт бичгийг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;

12.2.3.хуульчийн шалгалтын товд заасан хугацаанд бүртгүүлээгүй;

12.2.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай хүчингүй болгосон шийтгэлийн хугацаа дуусаагүй.

## **13 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад оруулахаас татгалзсан шийдвэрт гомдол гаргах журам**

13.1.Өргөдөл гаргагч нь хуульчийн шалгалтад оруулахаас татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шалгалт эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд гомдол гаргаж болно.

13.2.Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо хуульчийн шалгалт эхлэхээс гурваас доошгүй хоногийн өмнө гомдлыг эцэслэн шийдвэрлэнэ.

## **14 дүгээр зүйл.Хуульчийн шалгалт явуулах газар, хугацаа**

14.1.Хуульчдын холбоо хуульчийн шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

14.2.Хуульчийн шалгалтын товыг уг шалгалт эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

14.3.Хуульчийн шалгалтын товд шалгалтын хуваарь, бүртгэх журам, шалгалт авах газар, хугацаа, шалгалтын дарааллыг заана.

14.4.Хуульчийн шалгалтад оролцогчийг бүртгэх ажиллагаа шалгалтын товыг зарласан өдрөөс эхэлж, шалгалт эхлэхээс 30 хоногийн өмнө дууссан байна.

### **15 дугаар зүйл.Хуульчийн шалгалтын даалгавар**

15.1.Шалгалтын комисс хуульчийн шалгалтын даалгаврын нууцлалыг шалгалт эхлэх хүртэл, түүний хариултын нууцлалыг шалгалт дуусах хүртэл хамгаална.

15.2.Хуульчийн шалгалтын даалгаврын гүйцэтгэлийг тоогоор дугаарлах бөгөөд дугаартай холбогдох шалгалтад оролцогчийн нэр нууцлагдсан байна.

### **16 дугаар зүйл.Хуульчийн шалгалт авах журам**

16.1.Хуульчийн шалгалт нь эрх зүйн ерөнхий мэдлэгийг сорьсон сорилгын болон эрх зүйн салбарын хүрээнд тодорхой тохиолдлыг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлогын шалгалтын хэлбэрээр явагдана.

16.2.Хуульчийн шалгалтын үргэлжлэх нийт хугацаа гурав хоног байна.

16.3.Хуульчийн шалгалтад оролцогч сорилгын шалгалтын нийт онооны 60 ба түүнээс дээш хувийг авсан бол бодлогын шалгалтад орох эрхтэй болно.

16.4.Бодлогын шалгалтын даалгаврын гүйцэтгэлийг гурваас доошгүй шалгагчийн бүрэлдэхүүнтэйгээр дүгнэж, дүнг тэдгээрээс өгсөн үнэлгээний дунджаар гаргана

16.5.Сорилгын болон бодлогын шалгалтад авсан нийлбэр дүн нь хуульчийн шалгалтын нийт онооны 70 ба түүнээс дээш хувьд хүрсэн бол хуульчийн шалгалтад тэнцсэнд тооцно.

16.6.Шалгалтын комисс хуульчийн шалгалтын нэгдсэн дүнг шалгалт дууссанаас хойш ажлын таван өдөрт багтаан шалгалтад оролцогчдын нэрсийн жагсаалтад харгалзах тоон дугаараар гаргаж, нийтэд мэдээлнэ.

16.7.Хуульчийн шалгалттай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг журмаар зохицуулна.

16.8. Энэ хуулийн 16.7-д заасан журмыг Хуульчдын холбооны зөвлөл батална.

### **17 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад тэнцсэн тухай батламж олгох**

17.1.Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо хуульчийн шалгалт дууссанаас хойш 30 хоногийн дотор уг шалгалтад тэнцсэн этгээдэд батламж олгоно.

### **18 дугаар зүйл.Хуульчийн шалгалтад дахин орох**

18.1.Хуульчийн шалгалтад тэнцээгүй болон сахилгын шийтгэл хүлээж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө хугацаатай хүчингүй болгуулсан этгээд сахилгын шийтгэлийн хугацаа дууссанаас хойш хуульчийн шалгалтад дахин орох эрхтэй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ**

### **19 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүнийг олгох журам**

19.1.Хуульчийн шалгалтад тэнцэж батламж авсан этгээд батламж авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор Хуульчдын холбоонд гишүүнээр элсэх өргөдөл гаргана.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

19.2.1.хуульчийн шалгалтад тэнцсэн батламж;

19.2.2.эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэх талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

19.2.3.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүйг нотолсон эрүүл мэндийн тодорхойлолт;

19.2.4.гишүүний бүртгэлийн хураамж төлсөн баримт.

19.3.Хуульчдын холбоо нь өргөдөлд хавсаргасан баримт бичгийн үнэн зөв байдлыг шалгаж, хуульчид тавигдах зан байдлын болон эрүүл мэндийн шаардлагыг харгалзан гишүүнээр элсүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

19.4.Хуульчдын холбоо өргөдөл гаргагчийг гишүүнээр бүртгэж авсан тохиолдолд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно.

19.5.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй олгоно.

19.6.Хуульч нь холбогдох хуульд заасан мэргэжлийн шалгалтад оролцож тэнцсэн тохиолдолд шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчаар ажиллана.

19.7.Энэ хуулийн 10.3.5, 19.2.4-т заасан хураамжийн хэмжээг Хуульчдын холбооны зөвлөл тогтооно.

## **20 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл**

20.1.Дор дурдсан үндэслэл байвал хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлнэ:

20.1.1.өргөдөл гаргагч гэмт хэрэгт холбогдон эрх бүхий байгууллагад шалгагдаж байгаа;

20.1.2.өргөдөл гаргагч эрүүл мэндийн байдлын улмаас тодорхойгүй хугацаагаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах боломжгүй байгаа;

20.1.3.энэ хуулийн 10.3, 19.2-т заасан баримт бичигтэй холбоотой маргаан үүссэн;

20.1.4.цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэж байгаа.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл арилсан бол энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан журмын дагуу Хуульчдын холбооны гишүүнээр бүртгэж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

## **21 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл**

21.1.Дор дурдсан үндэслэл байвал өргөдөл гаргагчид хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзана:

21.1.1.санаатай гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон, эсхүл авлигын болон албан тушаалын хэрэгт буруутгагдаж хууль зүйн хариуцлага хүлээсэн;

21.1.2.энэ хуулийн 10.3, 19.2-т заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

21.1.3.төрийн албанд ажиллах эрхээ хасуулсан.



21.2.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

21.3.Энэ зүйлийн 21.1.1-д заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээснээс хойш Эрүүгийн хуулийн 1.10-т заасантай тэнцүү хугацаа өнгөрсөн бол энэ зүйлд заасан хязгаарлалт хамаарахгүй;

## **22 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

22.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно:

22.1.1.эрүүл мэндийн байдлын улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болсон;

22.1.2.хүүхэд асрах, эсхүл эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүнийг асрамжлах болсон;

22.1.3.гадаад улсад байнга оршин суух болсон;

22.1.4.хугацаат, гэрээт цэргийн алба хаах болсон;

22.1.5.энэ хуулийн 39.3-т заасан ажил, албан тушаалд томилогдсон;

22.1.6.төрийн улс төрийн албан тушаалд сонгогдсон, томилогдсон.

22.2.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ хуулийн 22.1-д зааснаас бусад үндэслэлээр түдгэлзүүлэхийг хориглно.

22.3.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ хуулийн 22.1-д заасан үндэслэлээр түдгэлзүүлэх асуудлыг холбогдох хүсэлт, эрх бүхий этгээдийн тодорхойлолт, дүгнэлтээр Хуульчдын холбооны Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

22.4.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хуульчийг энэ хуулийн 30.1.8-д заасан татвараас чөлөөлнө.

22.5.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл арилсан тохиолдолд Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн шийдвэрээр сэргээнэ.

## **23 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл**

23.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

23.1.1.хуульч өөрөө хүсэлт гаргасан;

23.1.2.хуурамч баримт бичиг бүрдүүлж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан нь тогтоогдсон;

23.1.3.хуульчаар ажиллаж байх хугацаандаа санаатай гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон;

23.1.4.энэ хуулийн 30.1.8-д заасан татварыг 3 сарын хугацаанд төлөөгүй;

23.1.5.энэ хуулийн 30.1.4-т заасан үүргээ 2 жилийн хугацаанд биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн;

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан үндэслэлээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

23.3.Энэ хуулийн 23.1-д заасан үндэслэлээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон бол тухайн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хуульчийн шалгалтад бүртгэхгүй.

## **24 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар болох**

24.1.Доор дурдсан тохиолдолд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар болно:

24.1.1.хуульч өөрөө хүсэлт гаргасан;

24.1.2.хуульч нас барсан, эсхүл хуульчийг нас барсанд тооцох тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

24.1.3.хуульчийн иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйг тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

24.2.Хуульчдын холбоо энэ хуулийн 24.1-д заасан үндэслэлээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар болсон бол хуульчийн бүртгэлд тэмдэглэгээ хийнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН ТАНГАРАГ, ЭРХ, ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

### **25 дугаар зүйл.Хуульчийн тангараг**

25.1.Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор "Хуульч би Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хуульчийн нийтлэг үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг үнэнч шударгаар биелүүлж, хуульчийн нэр хүндийг өндөрт өргөж явахаа батлан тангаргалъя. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ" гэж Хуульчдын холбоонд тангараг өргөнө.

25.2.Хуульчийн тангараг өргөх ёслолыг нээлттэй явуулна.

25.3.Хуульчийн тангараг өргөх ёслолын журмыг Хуульчдын холбооны зөвлөл батална.

## **26 дугаар зүйл.Хуульч нэрийг хэрэглэх**

26.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, хуульчийн тангараг өргөсөн хуульч "хуульч" нэрийг хэрэглэнэ.

26.2.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй, эсхүл хуульчийн мэргэлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчингүй болсон хүн "хуульч" нэр хэрэглэхийг хориглоно.

26.3.Хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцэж, зохих журмын дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан, энэ хуулийн 26.1-д заасан эрх бүхий хуульчийг Төрийн албаны тухай хуулийн 33.2.1-д заасан ерөнхий шалгалтаас чөлөөлж, тухайн шалгалтанд тэнцсэнээр тооцно.

## **27 дугаар зүйл.Хуульчийн эрхлэх мэргэжлийн үйл ажиллагаа**

27.1.Шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн хуульд заасан үйл ажиллагаа нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарна.

27.2.Шүүгч, прокуророос бусад хуульч дараах мэргэжлийн үйл ажиллагааг явуулах эрхтэй:

27.2.1.хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх, зөвлөмж, дүгнэлт гаргах;

27.2.2.хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиох, хянах, гэрчлэх;

27.2.3.иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх;

27.2.4.нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах;

27.2.5.хуулиар хориглоогүй бусад.

## **28 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм**

28.1.Хуульчид энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм /цаашид "Хуульчийн мэргэжлийн дүрэм" гэх/-тэй байна.

28.2.Хуульчийн мэргэжлийн дүрмийн зорилго нь хуульчдын мэргэжлийн үйл ажиллагааг чанартай, хариуцлагатай байлгах үүднээс хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэгдсэн стандарт бий болгоход оршино.

28.3.Хуульчийн мэргэжлийн дүрмээр хуульч, үйлчлүүлэгч, хуульчид хоорондын харилцаа, хуульчдын нийтийн өмнө хүлээх үүрэг, ашиг сонирхлын зөрчил, нууцлал, эрх хэмжээ, хараат бус байдал болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг зохицуулна.

28.4.Хуульчийн мэргэжлийн дүрмийг Хуульчдын холбооны их хурал батална.

28.5.Хуульчийн мэргэжлийн дүрэм нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой ёс зүй, сахилга, хариуцлагын хэм хэмжээтэй уялдсан байна.

## **29 дүгээр зүйл.Хуульчийн нийтлэг эрх**

29.1.Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах нийтлэг эрхийг эдэлнэ:

29.1.1.энэ хууль болон бусад хуульд заасан нөхцөл, баталгааг эдлэх, шаардах;

29.1.2.өөрт холбогдуулан гаргасан Хуульчдын холбооны шийдвэртэй танилцах, шийдвэрийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;

29.1.3.хуульд заасан бусад.

29.2.Хуульч энэ хуулийн 29.1-т заасан эрхээ хууль тогтоомж, хуульчийн мэргэжлийн дүрмийн хүрээнд хэрэгжүүлнэ.

## **30 дугаар зүйл.Хуульчийн нийтлэг үүрэг**

30.1.Хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон Хуульчийн мэргэжлийн дүрэмд захирагдах;

30.1.2.иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хууль бус үйлдэл хийхгүй байх;

30.1.3.хуульчийн мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээллийг хууль бусаар задруулахгүй байх;

30.1.4.хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах;

30.1.5.өөрийгөө ашиг сонирхлын зөрчилд болон хараат байдалд оруулахуйц харилцаа холбооноос зайлсхийх, бусдын хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах;

30.1.6.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан үүргийг биелүүлэх;

30.1.7.Хуульчдын холбооны үйл ажиллагаанд хамрагдах, тус холбооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

30.1.8.Хуульчдын холбооны гишүүн байж, гишүүний болон ерөнхий хорооны татварыг төлөх;

30.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

30.2.Энэ хуулийн 30.1.8-д заасан Хуульчдын холбооны гишүүний татварын хэмжээ хуульч бүрт адил байна.

30.3.Энэ хуулийн 30.1.8-д заасан хорооны татвар нь Хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгчдийг заавал гишүүнчлэлтэй байхаар хуульчилсан Өмгөөлөгчдийн холбооны татварын хувь, хэмжээтэй тэнцүү байна. Өмгөөлөгч ерөнхий хороонд давхардсан татвар төлөхгүй бөгөөд өмгөөлөгчдийг нэгтгэсэн ерөнхий хороо татваргүй байна.

30.4.Энэ хуулийн 30.1.8-д заасан ерөнхий хорооны татварыг Хуульчдын холбооны дансанд төвлөрүүлж, зохих журмын дагуу зарцуулна.

### **31 дүгээр зүйл.Хуульчид хориглох зүйл**

31.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараах үйлдлийг хориглоно:

31.1.1.Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд туслах, хатгах;

31.1.2.хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх;

31.1.3.шүүхэд төлөөлөх үйл ажиллагааг хууран мэхлэх, урвах, хууль бус аргаар явуулах;

31.1.4.Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, хууль ёсны зарчмын эсрэг үйл ажиллагаа явуулах;

31.1.5.төрийн байгууллага, албан тушаалтанд зүй бусаар нөлөөлөх, эсхүл хууль тогтоомж болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчиж хүссэн үр дүндээ хүрч чадах мэт илэрхийлэх;

31.1.6.шүүгч болон шүүхийн ажилтныг шүүхийн хууль тогтоомжийг санаатайгаар зөрчихөд хүргэх, туслах;

31.1.7.мэдүүлэг болон бусад нотлох баримтыг хуурамч гэдгийг мэдсээр байж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд ашиглах;

31.1.8.үйлчлүүлэгчийнхээ болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд нь өртөж байгаа этгээдийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн болон бусад этгээдийн нэрээр худалдан авах, эсхүл өөр бусад аргаар олж авах, эзэмших.

31.2.Энэ хуульд зааснаас бусад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг хуулиар тогтооно.

## **32 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууц**

32.1.Хуульчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой бүхий л мэдээлэл хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууцад хамаарна. Хуульч үйлчлүүлэгчийнхээ зөвшөөрөлгүйгээр мэдээллийг задруулах эрхгүй.

32.2.Аливаа этгээдээс хуульчид эрх зүйн туслалцаа хүсч хандсан болон үйлчлүүлэгчид хууль зүйн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан хуульчийг гэрчээр болон бусад байдлаар байцаах, нөхцөл байдлыг тодруулах зорилгоор мэдүүлэг, тайлбар авахыг хориглоно.

32.3.Хуульч мэргэжлийн үйл ажиллагааны нууцыг задруулах, эсхүл өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахыг хориглоно.

32.4.Хуульч мэргэжлийн үйл ажиллагааны нууцаа хугацаагүй хадгална.

32.5.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууцыг мэдэх болсон хуульчийн туслах, түүний байгууллагын бусад ажилтан уг нууцыг хадгалах үүрэгтэй.

32.6.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууцыг хуулиар хамгаална.

32.7.Хуульч энэ хуулийн 30.1.6-д үүргээ биелүүлснийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууц задруулсан гэж үзэхгүй.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧДЫН ХОЛБОО**

### **33 дугаар зүйл.Хуульчдын холбоо, түүний гишүүнчлэл**

33.1.Хуульчдын холбоо хуульчийн мэргэжлийн нэр хүнд, эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх болон энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

33.2.Хуульч бүр Хуульчдын холбооны гишүүн байна.

33.3.Хуульчид сайн дураараа нэгдэж төрийн бус байгууллага байгуулж болох бөгөөд хуульчдын байгуулсан төрийн бус байгууллага нь энэ хуультай зөрчилдөхгүй бол Хуульчдын холбооны үйл ажиллагаанд хорооны эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар оролцож болно.

33.4.Хуульчдын холбоо хуульчдын нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

33.5.Шүүгч, прокурорыг томилж, чөлөөлсөн болон өмгөөлөгч, нотариатчийн эрх олгосон буюу хүчингүй болгосон байгууллага холбогдох шийдвэрээ Хуульчдын холбоонд хүргүүлнэ.

33.6.Энэ хуулийн 33.4-т заасан бүртгэлийн журмыг Хуульчдын холбооны зөвлөл батална.

### **34 дүгээр зүйл.Хуульчдын холбооны чиг үүрэг**

34.1.Хуульчдын холбоо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.1.1.хуульчийн шалгалт зохион байгуулах;

34.1.2.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

34.1.3.хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцож нэгдсэн бүртгэлийг хөтлөх;

34.1.4.хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

34.1.5.Хуульчийн мэргэжлийн дүрэм батлах, сахиулах;  
34.1.6.шүүгчийн сонгон шалгаруулалтад хуульд заасан журмын дагуу оролцох;

34.1.7.хууль зүйн сургуулийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх;  
34.1.8.хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх;

34.1.9.хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, шүүхийн практик, хууль зүйн бодлогын чиглэлд судалгаа хийх;

34.1.10.мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажлыг зохион байгуулах;

34.1.11.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх.

34.2.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журмыг Хуульчдын холбооны Зөвлөл батална.

### **35 дугаар зүйл.Хуульчдын их хурал**

35.1.Хуульчдын өөрөө удирдах ёсны эрх барих дээд байгууллага нь Хуульчдын их хурал байна.

35.2.Хуульчдын их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.2.1.Хуульчдын холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

35.2.2.Хуульчийн мэргэжлийн дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

35.2.3.Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх;

35.2.4.Хуульчдын холбооны зөвлөлийн гишүүнийг батламжлах, чөлөөлөх;

35.2.5.Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүй, хариуцлагын асуудал эрхэлсэн хорооны бүрэлдэхүүнийг батламжлах, чөлөөлөх;

35.2.6.Хуульчдын холбооны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонсох, зөвлөмж өгөх;

35.2.7.энэ хуулийн 30.1.8-д заасан татварын хэмжээг тогтоох;

35.2.8.Хуульчдын холбооны дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.



35.3.Хуульчдын их хурлын ээлжит хуралдаан гурван жилд нэг удаа хуралдах бөгөөд Хуульчдын их хурал хуралдаан даргалагчаа сонгож, хуралдааны дэгээ тогтооно.

35.4.Хуульчдын их хуралд хуульчдын төлөөлөгчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

35.5.Хуульчдын их хуралд оролцох хуульчдын төлөөлөгчдийг сонгох журмыг Хуульчдын холбооны дүрмээр тогтооно.

35.6.Хуульчдын их хурлын төлөөлөгчдийн 20 хувь нь өмгөөлөгч, 40 хувь нь шүүгч, прокурор, 40 хувь нь бусад хуульч байна.

35.7.Хуульчдын их хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хуралдаан эхлэхээс 30 хоногийн өмнө Хуульчдын холбооны Ерөнхийлөгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

35.8.Хуульчдын их хурал энэ хуулийн 35.2.1, 35.2.2, 35.2.7-д заасан асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн дийлэнх олонхын саналаар, бусад асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар тус тус шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана.

35.9.Хуульчдын их хурал Хуульчдын холбооны гишүүний татварыг тогтоохдоо энэ хуулийн 30.2, 30.3-т заасан нөхцөлийг харгалзана.

35.10.Хуульчдын их хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар Хуульчдын их хуралд хүрэлцэн ирэх боломжгүй бол саналаа бичгээр битүүмжлэн ирүүлж болно.

35.11.Энэ хуулийн 35.10-т заасны дагуу ирсэн саналыг хэлэлцэх журмыг хуралдааны дэгээр зохицуулна.

## **36 дугаар зүйл.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч**

36.1.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч нь улс төрөөс ангид, хуульчийн хувьд манлайлагч, хуульчдын нэр хүнд, ёс зүйн хувьд үлгэр дуурайлал үзүүлэгч, хуульчдыг байр суурь, бодлогын хувьд илэрхийлэгч байна.

36.2.Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг улируулан сонгохгүй.

36.3.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.3.1.Хуульчдын холбооны зөвлөлтэй зөвшилцөн Хуульчдын их хурлыг зарлан хуралдуулах;

36.3.2.Хуульчдын холбооны зөвлөлийн хуралдааныг даргалах;  
36.3.3.Хуульчдын холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;  
36.3.4.Хуульчдын холбооны зөвлөлд Хуульчдын холбооны тамгын газрын даргад нэр дэвшүүлэх, чөлөөлөх;

36.3.5.Хуульчдын холбооны зөвлөлөөс сонгосон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс Улсын Их Хуралд санал болгох;

36.3.6.Хуульчдын холбооны зөвлөлөөс сонгосон Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигчдээс Улсын Их Хуралд санал болгох;

36.3.7.Хуульчдын холбооны зөвлөлөөс сонгосон Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлд уламжлах;

36.3.8.энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан хороодын ажлын үр дүнг улирал тутамд үнэлэх ажлыг зохион байгуулах, хорооны тэргүүн, дарга, удирдах зөвлөлийн гишүүдийг огцруулах тухай саналыг Зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх;

36.3.9.хууль болон Хуульчдын холбооны дүрмээр олгосон бусад бүрэн эрх.

36.4.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч Хуульчдын их хурлын чөлөөт цагт энэ хуулийн 35.2.4-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

36.5.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

### **37 дугаар зүйл.Хуульчдын холбооны зөвлөл**

37.1.Хуульчдын холбооны Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Хуульчдын холбооны үйл ажиллагааг бодлогын удирдлагаар хангах чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага байна.

37.2.Зөвлөл нь 35 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, өмгөөлөгч долоо, бусад хуульч 14 байна.

37.3.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно.

37.4.Зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

37.5.Энэ хуулийн 37.2-т заасан Зөвлөлийн гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр Зөвлөлийн хурал хүчинтэй болох бөгөөд хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр батлагдана.

37.6.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч Зөвлөлийн хуралдааныг даргалах бөгөөд Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн санал тэнцсэнээс бусад тохиолдолд саналын эрхгүй байна.

37.7.Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.7.1.Хуульчдын холбооны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

37.7.2.Хуульчийн мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэж Хуульчдын их хуралд оруулах, Хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх;

37.7.3.энэ хуульд заасан бусад дүрэм, журмыг батлах;

37.7.4.Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүй, хариуцлагын асуудал эрхэлсэн хорооноос бусад Чиг үүргийн хороог байгуулж, даргыг нь гурван жилийн хугацаатайгаар томилох;

37.7.5.Чиг үүргийн хорооноос бусад хороог батламжлах;

37.7.6.Хуульчдын холбооны хяналтын зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/-ийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх;

37.7.7.Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн цалингийн хэмжээг тогтоох;

37.7.8.Хуульчдын холбооны Тамгын газрын дарга /цаашид "Тамгын газрын дарга" гэх/-ыг томилох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох;

37.7.9.Хуульчдын холбооны тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/-ын бүтэц, орон тоог батлах, ажилтны цалингийн хэмжээг тогтоох;

37.7.10.Хуульчдын холбооны төсөв, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, батлах;

37.7.11.Хуульчдын холбооны орон нутаг дахь салбар, нэгжийг байгуулах, татан буулгах;

37.7.12.Хуульчдын холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар хуульчдаас гаргасан өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх, шаардлагатай бол Хуульчдын их хурлаар хэлэлцүүлэх;

37.7.13.энэ хууль болон Хуульчдын холбооны дүрэм, Хуульчдын холбооноос баталсан журмын биелэлтэд хяналт тавих;

37.7.14.энэ хууль болон Хуульчдын холбооны дүрэмд зааснаас бусад холбооны зохион байгуулалтын бүтцийг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

37.7.15.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд санал болгох нэр дэвшигчдийг сонгох.

37.8.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа нийтэд ил тод байх бөгөөд хууль зүйн шаардлага хангасан хуульчид нэрээ дэвшүүлэх нийтлэг тэгш боломжийг олгосон байна.

37.9.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хариуцах бөгөөд энэ ажиллагаанд Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо хяналт тавина.

37.10.Энэ хуулийн 37.9-д заасан ажлын хэсэгт Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хорооны төлөөллөөс гадна Ерөнхий хороодын төлөөллийг оруулна.

37.11.Энэ хуулийн 37.10-т заасан ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 45-аас доошгүй хоногийн өмнө нэр дэвшүүлэх тухай асуудлыг олон нийтэд зарлаж, нэрээ дэвшүүлэхэд тавих шаардлага болон бүртгэх, сонгон шалгаруулах хугацааг тодорхой заасан мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх ажлыг зохион байгуулж, 15-аас доошгүй өдөр Хуульчдын холбооны цахим хуудсанд байршуулна.

37.12.Ажлын хэсэг энэ хуулийн 37.11-д заасан хугацаанд бүртгүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэрээ дэвшүүлсэн хүний зураг бүхий боловсрол, ажлын дадлага туршлага болон холбогдох бусад мэдээллийг агуулсан танилцуулгыг 15-аас доошгүй өдөр Хуульчдын холбооны цахим хуудсанд байршуулж, олон нийтийн санал, сэтгэгдлийг хүлээн авах ажиллагааг зохион байгуулна.

37.13.Ажлын хэсэг энэ хуулийн 37.11, 37.12-т заасан ажиллагаа дуусмагц бүртгэгдсэн нэр дэвшигчид болон тэдгээрийн талаарх олон нийтийн санал, сэтгэгдлийг Зөвлөлийн хуралд нээлттэй танилцуулна.

37.14.Зөвлөл энэ хуулийн 37.13-т заасны дагуу танилцуулагдсан нэр дэвшигчдээс Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнийг шууд сонгох бол Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны нэр дэвшигчдээс тус бүр зургаан хүнийг сонгож Хуульчдын холбооны Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

37.15.Зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

37.16.Зөвлөлийн хуралдааныг нээлттэй явуулна.

## **38 дугаар зүйл.Хуульчдын холбооны хороод**

38.1.Хуульчдын холбоо чиг үүргээ хороодоор дамжуулан хэрэгжүүлнэ.

38.2.Хуульчдын холбоо нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдын гэсэн дөрвөн ерөнхий хороотой байна.

38.3.Ерөнхий хороо нь харьяалагдаж буй хуульчдын нийтлэг эрхийг хангах үндсэн зорилго, чиглэлийн хүрээнд ажиллана.

38.4.Энэ хуулиар Хуульчдын холбооны тодорхой чиг үүргийг тусгайлан хариуцаж ажиллахаар заасан хороодыг "Чиг үүргийн хороо" гэж нэрлэх бөгөөд Чиг үүргийн хороо үйл ажиллагаагаа Зөвлөлийн өмнө хариуцан тайлагнана.

38.5.Чиг үүргийн хорооны хуралдаан гишүүдийн олонх ирснээр хүчинтэй болох бөгөөд, хуралдаанаас гарах шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд хорооны даргын саналаар шийдвэрлэнэ.

38.6.Эрх зүйн салбар, мэргэшил болон тусгай асуудлаар холбооны гишүүд сайн дураараа нэгдэж хороо /цаашид "Сайн дурын хороо" гэх/ байгуулж болно.

38.7.Энэ хуулийн 38.6-д заасан хороо нь дараах шаардлагыг хангана:

38.7.1.хороонд нэгдсэн гишүүдийн тоо 50-оос доошгүй байх;

38.7.2.хорооны оноосон нэр, түүнийг тодорхойлж байгаа эрх зүйн салбар, мэргэшил, тусгай сонирхол нь үйл ажиллагаа явуулж байгаа бусад хороотой давхцахгүй байх;

38.7.3.хорооны үйл ажиллагаа Чиг үүргийн хорооны үйл ажиллагаатай зөрчилдөхгүй байх.

38.8.Энэ хуулийн 38.7-д заасан шаардлагыг хангаагүй хороог Зөвлөл батламжлахгүй.

38.9.Энэ хуулийн 38.6-д заасан хорооны тэргүүн болон удирдах зөвлөлийн гишүүдийг тухайн хорооны гишүүд дотроосоо сонгох бөгөөд тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.

38.10.Хуульч сайн дурын гурваас илүүгүй хороонд харьяалагдаж, Хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

38.11.Хуульч Чиг үүргийн хорооны гишүүнээр ажиллавал Чиг үүргийн болон сайн дурын хороог оролцуулаад таваас илүүгүй хороонд ажиллаж болно. Энэ зүйлд заасан нөхцөл нь энэ хуулийн 38.10-т заасан чиг үүргийн хорооноос бусад хороонд харьяалагдах дээд хязгаарыг хөндөхгүй.

38.12.Энэ хуулийн 38.6-т заасан хороо тухайн хорооныхоо гишүүдийн хүрээнд татвартай байж болно.

38.13.Ерөнхий хороо болон Чиг үүргийн хорооны энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Хуульчдын холбооны дүрмээр зохицуулна.

38.14.Сайн дурын хорооны энэ хуулиар зохицуулаагүй харилцааг хороо тус бүрийн дүрмээр зохицуулна.

### **39 дүгээр зүйл. Тамгын газар**

39.1.Тамгын газар нь Хуульчдын холбоо, түүний Чиг үүргийн хороодын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, бусад хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

39.2.Тамгын газрыг Тамгын газрын дарга удирдана.

39.3.Тамгын газрын дарга болон бусад ажилтан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй хүн байх бөгөөд хэрэв хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй бол уг зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

39.4.Тамгын газрын даргын эрх хэмжээг Хуульчдын холбооны дүрмээр тогтооно.

### **40 дүгээр зүйл.Хяналтын зөвлөл**

40.1.Хяналтын зөвлөл нь Хуульчдын холбооны эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

40.2.Хяналтын зөвлөл нь хуульчдын төлөөллөөс бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг гурван жилийн хугацаагаар томилно.

### **41 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо**

41.1.Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид "Шалгалтын хороо" гэх/ нь нэр хүнд бүхий Хуульчдын холбооны гишүүн хуульч болон хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

41.2.Шалгалтын хорооны бүрэлдэхүүнийг Зөвлөл батална.

41.3.Шалгалтын хороо дараах эрх хэмжээтэй байна:

41.3.1.хуульчийн шалгалт зохион байгуулах үүрэг бүхий Шалгалтын комисс байгуулах;

41.3.2.хуульчийн шалгалт зохион байгуулах журам боловсруулж, Зөвлөлөөр батлуулах;

41.3.3.хуульчийн шалгалтын зохион байгуулалт болон даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөхтэй холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэх.

41.4.Шалгалтын хороо хуульчийн шалгалт зохион байгуулах тухай бүрд Шалгалтын комиссыг байгуулна.

41.5.Шалгалтын комисс нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

41.5.1.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хуульчийн шалгалтыг зохион байгуулах;

41.5.2.сорилгын болон бодлогын шалгалтад оролцогчдын даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх;

41.5.3.хуульчийн шалгалтын дүнг үнэн зөв нэгтгэн Шалгалтын хороонд хүргүүлэх;

41.5.4.шалгалтын даалгаврын боловсруулалт, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

41.6.Тамгын газрын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгчөөс бусад шалгалтын комиссын гишүүнд урамшуулал олгоно.

41.7.Энэ хуулийн 41.5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, энэ хуулийн 41.6-д заасан урамшууллыг олгох журмыг Зөвлөл тогтооно.

## **42 дугаар зүйл.Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо**

42.1.Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид "Сургалтын хороо" гэх/ нь нэр хүнд бүхий Хуульчдын холбооны гишүүн хуульч болон хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

42.2.Сургалтын хороо нь хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлж, хуульчийн үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж хэлэлцэх, сургалт явуулах багш нарын талаар санал өгөх, сургалтын явц үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, үргэлжилсэн сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг боловсруулж Зөвлөлөөр батлуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

42.3.Сургалтын хороо нь хуульчийн үргэлжилсэн сургалтын чанар, хүртээмж, заавал мэдвэл зохих агуулгад суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх, хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулахад Хуульчдын холбооны бусад хороог оролцуулах ажлыг хариуцна.

42.4.Энэ хуулийн 30.1.4-т заасан багц цаг, түүнийг хангах журмыг Хуульчдын холбооны зөвлөл батална.

### **43 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүй, хариуцлагын асуудал эрхэлсэн хороо**

43.1.Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүй, хариуцлагын асуудал эрхэлсэн хороо нь энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **44 дүгээр зүйл.Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо**

44.1.Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо /цаашид "Хуульчдын эрхийг хамгаалах хороо" гэх/ нь нэр хүнд бүхий Хуульчдын холбооны гишүүн хуульч болон хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

44.2.Хуульчдын эрхийг хамгаалах хороонд шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчдын хорооны төлөөлөл тус бүр гурав, бусад хуульчдын хороодын нийт төлөөлөл дөрөв байна.

44.3.Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих замаар хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах чиг үүрэгтэй бөгөөд дараах үйл ажиллагаа явуулна:

44.3.1.хуульчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах;

44.3.2.хуульчийн өмнөөс түүний эрхийг хамгаалах асуудлаар шаардлагатай хэвлэлийн бага хурал хийх, тайлан, зөвлөмж гаргах.

44.4.Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь энэ хуулийн 44.3-т заасан чиг үүргээ хуульчдын нэгдсэн сонирхол хөндөгдсөн нөхцөлд өөрийн санаачилгаар болон Хуульчдын холбооны даалгавраар хэрэгжүүлнэ.

44.5.Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлт, Улсын ерөнхий прокурорын газар, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатчдын танхимтай хамтарсан комисс байгуулан ажиллаж болно.



## **45 дугаар зүйл.Хууль зүйн сургуулийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх хороо**

45.1.Хууль зүйн сургуулийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх хороо /цаашид “Магадлан итгэмжлэх хороо” гэх/ нь хууль зүйн сургуулийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх журам, хууль зүйн боловсролын зохистой хөтөлбөрийн стандартын шаардлагыг тогтоох, сургалтын чанар, сургалтын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах зэрэг ажлыг зохион байгуулна.

45.2.Магадлан итгэмжлэлийн хороо нь Хууль зүйн шинжлэх ухааныг дэмжих хорооны гишүүд болон хуульч профессоруудын харилцан тэнцүү төлөөллөөс бүрдэнэ.

45.3.Магадлан итгэмжлэх хороо нь магадлан итгэмжлэх комисс, шинжээч, бусад ажилтнуудад тавигдах шаардлага, шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн тогтооно. Комиссын бүрэлдэхүүнийг Магадлан итгэмжлэх хороо батална.

45.4.Магадлан итгэмжлэх комиссын бүрэлдэхүүн нь хуульч профессор, Ерөнхий хороодын төлөөлөл, магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр бүхий хууль зүйн сургуулийн багш нарын төлөөлөл, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

45.5.Магадлан итгэмжлэлийн хорооны бүрэлдэхүүнд хууль зүйн сургуулийн оюутны төлөөллийг оруулж болно.

## **46 дугаар зүйл.Хууль зүйн сургуулийн магадлан итгэмжлэл**

46.1.Хууль зүйн сургуулийн эрх зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөр нь энэ хуульд заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн байна.

46.2.Энэ хуулийн 46.1-д заасан магадлан итгэмжлэлийг Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэх комисс байгуулах замаар хэрэгжүүлнэ.

46.3.Магадлан итгэмжлэх комисс нь хууль зүйн сургуульд хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг хийж, Боловсролын тухай хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

46.4.Хуульчийн мэргэжлийн боловсролыг эзэмшиж, хуульчаар бэлтгэгдэж байгаа оюутан төгсөхдөө 120 багц цагийг хангасан байх ба оюутны суралцах хугацаа дөрвөн жилээс багагүй байна.

46.5.Энэ хуулийн 46.4-т заасан багц цаг нь Хуульчдын холбооны баталсан хууль зүйн боловсролын зохистой хөтөлбөрийн мэргэжлийн хичээлийн агуулгаар илэрхийлэгдэнэ.

46.6.Магадлан итгэмжлэл хийлгэхээр хүсэлт гаргасан хууль зүйн сургууль нь энэ хуульд заасан сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан талаарх үндэслэл бүхий төлөвлөгөө, хүсэлт ирүүлсэн тохиолдолд тухайн хөтөлбөрийг магадлан итгэмжилж болно.

46.7.Магадлан итгэмжлэх комиссын дүрэм, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага, хууль зүйн сургуулийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх журам, магадлан итгэмжлэлийн төлбөрийн хэмжээг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

46.8.Хуульчдын холбоо нь сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зургаан жил тутамд хийнэ.

#### **47 дугаар зүйл.Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх, бодлогын нөлөөлөл хийх**

47.1.Улсын Их Хурлын Тамгын газрын хүсэлтээр хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх ажлыг Хуульчдын холбоо зохион байгуулна.

47.2.Хууль зүйн бодлогын асуудлаарх хуульчдын байр суурийг Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн өмнө Хуульчдын холбоо төлөөлнө.

47.3.Хуульчдын холбоо бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулах асуудлыг Тамгын газраараа дамжуулан хэрэгжүүлэх ба түүний дэргэд Зөвлөхүүдийн зөвлөл ажиллана.

47.4.Энэ хуулийн 47.3-т заасан Зөвлөхүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүн одоо эрхэлж байгаа ажил нь давхар ажил эрхлэлтээр хязгаарлагдаагүй бол Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан болон нэр хүнд бүхий хуульчдын төлөөллөөс бүрдэнэ.

47.5.Хуульчдын холбоо дэргэдээ бодлогын асуудлаар дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний бүтэцтэй байж болно.

47.6.Энэ хуулийн 47.3-т заасан Зөвлөхүүдийн зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, бүтэц, бүрэлдэхүүнийг Зөвлөл батална.

#### **48 дугаар зүйл.Шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох**

48.1.Шүүхийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнийг Хуульчдын холбоо энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан журмын дагуу санал болгож, Шүүхийн ерөнхий зөвлөл томилно.

48.2.Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, санал болгох журмыг энэ хуульд нийцүүлэн Зөвлөл батална.

48.3.Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуульд заасан болон холбогдох бусад лавлагаа, дүгнэлтийг Хуульчдын холбоо гаргана.

#### **49 дүгээр зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх**

49.1.Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгох, санал болгох асуудлыг Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хууль болон энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

49.2.Хуульд заасан болзол, шаардлагыг хангасан хуульч нэр дэвших хүсэлтдээ тухайн болзол, шаардлагыг хангасаныг нотлох баримт бичгийг хавсаргана.

49.3.Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, санал болгохтой холбогдсон бусад асуудлыг энэ хууль, Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуульд нийцүүлэн Зөвлөл батална.

#### **50 дугаар зүйл.Хуульчдын холбооны зохион байгуулалт, санхүүжилт**

50.1.Хуульчдын холбоо, түүний Чиг үүргийн хорооноос байгуулагдах комисс нь нэг удаагийн байна.

50.2.Хуульчдын холбооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Хуульчдын холбооны дүрмээр зохицуулна.

50.3.Хуульчдын холбооны санхүүжилт нь татвар, хандив, хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамж, гишүүний бүртгэлийн хураамж, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэсний орлого, хэвлэн нийтлэлийн ашгаас бүрдэнэ.

50.4.Хуульчдын холбоо нь тодорхой чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэхээр төрөөс санхүүжилт авах, улсын болон гадаадын байгууллагын хандив, тусламж авч, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж болно.

50.5.Хуульчдын холбооны санхүүгийн тайлан нээлттэй байх ба санхүүгийн аудитыг хоёр жил тутамд нэг удаа хийлгэж, гишүүддээ тайлагнана.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ДҮРЭМ, ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО, ТҮҮНИЙ АЖИЛЛАХ ЖУРАМ**

## **51 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүй, хариуцлагын асуудал эрхэлсэн хороо, түүний бүрэн эрх**

51.1.Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүй, хариуцлагын асуудал эрхэлсэн хороо /цаашид “Ёс зүй, хариуцлагын хороо” гэх/ нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдалд дүгнэлт гаргах, энэ хууль, Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэхийг болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

51.2.Ёс зүй, хариуцлагын хороо 30 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна. Ёс зүй, хариуцлагын хорооны гишүүнийг нэг удаа улируулан ажиллуулж болно.

51.3.Ёс зүй, хариуцлагын хороо нэр хүндтэй хуульчдаас бүрдэх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч болон бусад хуульчдын төлөөлөл харилцан тэнцүү байна.

51.4.Ёс зүй, хариуцлагын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх эрх энэ хуулийн 38.2-т заасан ерөнхий хороодод байна.

51.5.Ёс зүй, хариуцлагын хорооны гишүүнийг Хуульчдын холбооны нийт гишүүдээс сонгож, Их хурал батламжилна.

51.6.Ёс зүй, хариуцлагын хорооны даргыг гишүүд нь дотроосоо нэр дэвшүүлж, нууц санал хураалтаар олонхийн санал авсан хүнийг сонгож тогтоол гаргана.

51.7.Ёс зүй, хариуцлагын хорооны гишүүдэд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах үүрэг бүхий тусгай нэгжийг Хуульчдын холбооны Тамгын газрын бүтцэд байгуулан ажиллуулна.

51.8.Ёс зүй, хариуцлагын хорооны даргаас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах ажлыг Хуульчдын холбооны Тамгын газар хариуцна.

51.9.Хуульчдын холбооны Тамгын газар энэ хуулийн 51.7-д заасан нэгжийн үйл ажиллагааны үр дүнг Ёс зүй, хариуцлагын хорооны өмнө хариуцаж тайлагнана.

51.10.Ёс зүй, хариуцлагын хороо нь энэ хуулийн 51.1-д заасан дүгнэлт, өргөдөл, гомдлыг энэ хуулийн 51.3-т заасан хуульчдын аль нэг нь давамгайлаагүй төлөөллөөс бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

51.11.Ёс зүй, хариуцлагын хорооны өргөдөл, гомдол хуваарилах, хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилохтой холбогдсон журмыг Зөвлөл батална.

51.12.Ёс зүй, хариуцлагын хорооны гишүүдэд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах үүрэг бүхий энэ хуулийн 51.7-д заасан нэгжийн орон тоо, ажиллах журмыг Хуульчдын холбооны Тамгын газрын санал болгосноор Зөвлөл батална.

51.13.Ёс зүй, хариуцлагын хороо нь хуульчийн энэ хуулийн 30.1.6-д заасан үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.

51.14.Ёс зүй, хариуцлагын хороо нь Хуульчдын холбооны Тамгын газар, холбогдох бусад хороодыг манлайлж дараах ажлыг хамтран зохион байгуулж болно:

51.14.1.Хуульчийн мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

51.14.2.Хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

51.14.3.хуульчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох;

51.14.4.хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийх.

## **52 дугаар зүйл.Дүгнэлт гаргах, өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх**

52.1.Ёс зүй, хариуцлагын хороо хуульчид холбогдуулан гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй.

52.2.Ёс зүй, хариуцлагын хорооны 51.10-т заасан бүрэлдэхүүн өргөдөл, гомдол, хүсэлттэй холбогдуулж мэдээлэл цуглуулах, мэргэжлийн дүгнэлт гаргуулах зорилгоор бие даасан шинжээч томилох эрхтэй.

52.3.Ёс зүй, хариуцлагын хороо дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргана:

52.3.1.өмгөөлөгч болон үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааны талаар үйлчлүүлэгчийн гомдлоор;

52.3.2.шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчийн Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн тухай болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэнтэй холбоотой үүссэн маргааныг шүүгч, прокурор, өмгөөлөгч, иргэдийн гомдлоор;

52.3.3.хуульч энэ хуулийг болон Хуульчдын холбооны хууль ёсны шийдвэр, үүрэг даалгаврыг зөрчсөнтэй холбоотой маргааныг Хуульчдын холбооны хүсэлтээр.

52.4.Энэ хуулийн 52.3.3-т заасан Хуульчдын холбооны хүсэлтийг зохих хороод гаргах бөгөөд хорооноос бусад бүтэц гомдол гаргах бол Тамгын газар төлөөлнө.

52.5.Энэ хуулийн 52.3-т заасан дүгнэлт хуульчийн эсрэг гаргасан бол Ёс зүй, хариуцлагын хороо дараах арга хэмжээг авна:

52.5.1.шүүгчид холбогдох дүгнэлтийг Шүүхийн сахилгын хороонд хүргүүлэх;

52.5.2.прокурорт холбогдох дүгнэлтийг Прокурорын ёс зүйн зөвлөлд хүргүүлэх;

52.5.3.өмгөөлөгчид холбогдох дүгнэлтийг Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд хүргүүлэх;

52.5.4.нотариатчид холбогдох дүгнэлтийг Монголын нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлд хүргүүлэх;

52.5.5.шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчаас бусад хуульчид энэ хуульд заасан хариулага хүлээлгэх.

52.6.Энэ хуулийн 52.3, 52.5-д заасан дүгнэлт нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болох бөгөөд энэ хуулийн 52.5.1-52.5.4-т заасан байгууллага Ёс зүй, хариуцлагын хорооны дүгнэлтэд дурдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэнээ нийтэд мэдээлнэ.

52.7.Дүгнэлт гаргах, өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг Хуульчдын холбоо хариуцна.

### **53 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг мэдэгдэх**

53.1.Хуульч энэ хууль, Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг Ёс зүй, хариуцлагын хороонд мэдэгдэх үүрэгтэй.

53.2.Энэ хуулийн 53.1-д заасан хуульчийн мэдэгдэх үүрэг нь энэ хуулийн 32.1-д заасан мэдээлэл болон Хуульчдын холбооны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцад хамаарах мэдээллийг задруулахыг шаардахгүй.

## **54 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хүлээлгэх хариуцлага**

54.1.Энэ хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн энэ хуулийн 52.5.5-д заасан хуульчид Ёс зүй, хариуцлагын хороо дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

54.1.1.хаалттай болон нээлтэй сануулах;

54.1.2.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;

54.1.3.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй хүчингүй болгох.

54.2.Зөрчил гаргасан хуульчид өөрт нь ганцаарчлан сануулахыг хаалттай сануулах, нийтэд зарлаж сануулахыг нээлттэй сануулах гэнэ.

54.3.Ёс зүй, хариуцлагын хорооноос хуульчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай түдгэлзүүлсэн бол уул хугацаа дуусгавар болсноор тухайн эрх болон зөвшөөрөл сэргээгдэнэ.

54.4.Хуульчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй түдгэлзүүлсэн бол хариуцлага тооцсон өдрөөс хойш зургаан сар тутамд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээх асуудлыг Ёс зүй, хариуцлагын хороо шийдвэрлэнэ.

54.5.Ёс зүй, хариуцлагын хорооноос хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай хүчингүй болгосон бол уг хугацаа дуусгавар болсны дараа тухайн этгээд энэ хуульд заасны дагуу хуульчийн шалгалтад дахин орж болно.

54.6.Ёс зүй, хариуцлагын хорооноос хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгосон бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дахин олгогдохгүй.

54.7.Ёс зүй, хариуцлагын хороо ёс зүйн болон нөлөөллийн сургалтад албадан суулгах нэмэгдэл шийтгэлийг ногдуулж болох бөгөөд уг сургалтын зардлыг шийтгэл хүлээсэн хуульч өөрөө хариуцна.

## **55 дугаар зүйл.Ёс зүй, хариуцлагын хорооны шийдвэрийг шүүхэд давж заалдах**

55.1.Энэ хуулийн 52.5.5-д заасан хуульч Ёс зүй, хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

55.2. Давж заалдах гомдол гаргасан бол Ёс зүй, хариуцлагын хорооны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэнэ.

55.3. Хуульч нь энэ хуулийн 55.1-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ Ёс зүй, хариуцлагын хороонд гаргах бөгөөд уг хүсэлтийг хангах эсэхийг тухайн хороо тогтоол гарган шийдвэрлэнэ.

55.4. Энэ хуульд зохицуулснаас бусад давж заалдах гомдлыг гаргах, хүлээн авахтай холбогдсон харилцааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **56 дугаар зүйл. Төрийн байгууллага, албан тушаалтанд хориглох зүйл**

56.1. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Хуульчдын холбооноос энэ хуулийг зохих ёсоор хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтнаас нөлөөлөх, саад хийх аливаа үйлдлийг хориглоно.

### **57 дугаар зүйл. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих**

57.1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх талаарх Хуульчдын холбооны үйл ажиллагаанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэмжлэг үзүүлж түүнийхээ хүрээнд хяналт тавина.

57.2. Улсын Их Хурал, Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталсан хууль, тогтоол, шийдвэр болон бүртгэсэн нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг тухай бүр Хуульчдын холбоонд хүргүүлж, хуульчдыг эрх зүйн мэдээллээр хангах, хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

57.3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо хяналт тавина.

### **58 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

58.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **59 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

59.1. Энэ хуулийг 2020 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ГАРЫН ҮСЭГ**